

## АГУУЛГА

<b>Бүлэг 1. Төслийн товч танилцуулга .....</b>	<b>3</b>
2.2.Төслийн хүчин чадал .....	7
<b>Бүлэг 2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга .....</b>	<b>8</b>
Төслийн ерөнхий танилцуулга .....	8
Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, буруулах арга зам .....	9
Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний зөвлөмж.....	15
<b>Бүлэг 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт..</b>	<b>16</b>
3.1 Төслөөс агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	16
3.2. Төслөөс усны чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	17
3.3.. Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	19
3.4. Төслөөс ургамал, амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	20
3.5. ТХГН, түүх, соёлын дурсгалт зүйлст үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	22
<b>Бүлэг 4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....</b>	<b>23</b>
<b>Бүлэг 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....</b>	<b>23</b>
<b>БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>28</b>
<b>Бүлэг 7. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....</b>	<b>29</b>
<b>Бүлэг 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....</b>	<b>29</b>
<b>Бүлэг 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....</b>	<b>32</b>
<b>Бүлэг 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....</b>	<b>34</b>
<b>Бүлэг 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....</b>	<b>38</b>
<b>Бүлэг 12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....</b>	<b>39</b>
<b>Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөөний нэгдсэн төсөв, дүгнэлт .....</b>	<b>40</b>

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Талбайн байршлын координат .....	3
Хүснэгт 2. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ .....	16
Хүснэгт 3. Усны нөөц, чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ .....	18
Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх нөлөөлөл .....	20
Хүснэгт 5. Ургамалжилтын зүйлийн бүрэлдэхүүн, 2024.12.21 .....	20
Хүснэгт 6. Ургамлан бүрхэвчийн байдал .....	21
Хүснэгт 7. Химийн бодисоос ургамлан нөмрөгт учруулах нөлөөлөл.....	21
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
Хүснэгт 9. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .....	28
Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	29
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	32
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	35
Хүснэгт 13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	38
Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа.....	39
Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт .....	40

### Зургийн жагсаалт

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	4
Зураг 2. Төслийн талбайн орчны ерөнхий зураг .....	4
Зураг 3. Химийн бодисын агуулахын фото зураг.....	5
Зураг 4. Дээж авах цэгийн байршил.....	37

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:** Гал импекс ХХК

**Төсөл хэрэгжүүлэгчийн регистрийн дугаар:** 2120712

**Төслийн нэр:** Галын аюулгүй байдлын багаж хэрэгслийн агуулах, үйлдвэр

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 20-р хороо, Үйлдвэрийн барилга-150, конторын барилга-152

**Холбоо барих утас:** 11463614, 94990101

**Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:** Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хорооны нутаг дэвсгэрт 150-р цэргийн ангийн баруун, төв цэвэрлэх байгууламжийн зүүн талд

**Төслийн зорилго:** Монгол Улсад галын аюулгүй байдлын тоног төхөөрөмж, хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэж, чанартай бүтээгдэхүүнээр дотоодын зах зээлийг хангах.

**Төслийн эцсийн бүтээгдэхүүн:**

- Гал унтраах систем
- Галын дохиоллын систем
- Галын спринклер систем
- Галын унтраагуур
- Галын багаж хэрэгсэл

**Газар ашиглах, эзэмших шийдвэр:** Нийслэлийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн А/571 тоот захирамж

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар:** 000306050

**Талбайн хэмжээ /м<sup>2</sup>/:** 1600 м<sup>2</sup>

### Хүснэгт 1. Талбайн байршлын координат

№	X	Y	Талбайн хэмжээ, м <sup>2</sup>
1	629694.82	5309769.36	1600 м <sup>2</sup>
2	629662.74	5309759.39	
3	629644.26	5309812.18	
4	629656.72	5309816.43	
5	629686.07	5309826.45	
6	629705.02	5309772.53	

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Гал импекс” ХХК-ийн Галын аюулгүй байдлын багаж хэрэгслийн агуулах, үйлдвэр төсөл

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил



Зураг 2. Төслийн талбайн орчны ерөнхий зураг



Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Гал импекс” ХХК-ийн Галын аюулгүй байдлын багаж хэрэгслийн агуулах, үйлдвэр төсөл

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 3. Химийн бодисын агуулахын фото зураг



Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Гал импекс” ХХК-ийн Галын аюулгүй байдлын багаж хэрэгслийн агуулах, үйлдвэр төсөл

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



## 2.2.Төслийн хүчин чадал

- Гал унтраах төхөөрөмж: 100 нэгж / жил
- Галын дохиоллын систем: 200 систем / жил
- Ус цацагч төхөөрөмж (спринклер): 5000 ширхэг / жил

### Төсөл хэрэгжүүлэхэд ашиглах үндсэн тоног төхөөрөмж

- Хийн унтраах системийн баллон
- Даралт мэдрэгч
- Галын дохиоллын кабель
- Сприклер төхөөрөмж
- Хавхалга, холбох хэрэгслүүд

### Төсөл хэрэгжих ойролцоо

- 2025 оны 06-р сараас 2027 оны 06-р сар хүртэл

### Нийгмийн асуудал

#### Ажиллах хүчний хэрэгцээ:

- Үйлдвэрийн ажилтан 25 хүн
- Засвар үйлчилгээний ажилтан 5 хүн
- Борлуулалт, маркетингийн ажилтан 5 хүн

#### Ажиллах хүчний эх үүсвэр:

- Улаанбаатар болон орон нутгаас

#### Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын асуудал:

- Хөдөлмөр хамгааллын сургалт
- Хамгаалах хэрэгслээр бүрэн хангана

## БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### *Төслийн ерөнхий танилцуулга*

“Гал импекс” ХХК-ийн Галын аюулгүй байдлын багаж хэрэгслийн агуулах, үйлдвэр төсөл нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн химийн бодисын агуулахтай байна.

“Гал импекс” ХХК нь 1971 онд “Гал” Улсын үйлдвэрийн газар нэртэй байгуулагдаж, 2002 оны 10-р сарын 22-нд хувьчлагдан, одоог хүртэл галын аюулгүй байдлын систем буюу галын дохиоллын систем угсралт, галын спринклер систем суурилуулалт, галын багаж хэрэгсэл үйлдвэрлэл, бүх төрлийн галын хорны худалдаа, цэнэглэлт, галын аюулгүй байдлын зөвлөгөө, шийдэл, сургалт, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн худалдаа, үйлдвэрлэл зэрэг үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

### **Төслийн физик газарзүй ба эдийн засгийн хөгжил**

**Цаг уур амьсгал:** Улаанбаатар хот орчим нь уур амьсгалын хуурайдуу сэрүүвтэр мужийн нэн хүйтэн дэд мужид хамрагдана. Уур амьсгалын үндсэн нөхцөл байдал нь эх газрын эрс тэс уур амьсгалаар тодорхойлогдоно. Агаарын олон жилийн дундаж температур  $-1.2^{\circ}\text{C}$  хамгийн хүйтэн 1 дүгээр сард  $-39.6^{\circ}\text{C}$ , хамгийн дулаан нь 7 дугаар сард  $+34.5^{\circ}\text{C}$ , байдаг бөгөөд агаарын температурын агууриг  $74.1^{\circ}\text{C}$  байдаг. Улаанбаатар хотын бүсэд салхи ихэвчлэн хойд баруун хойноосоо чиглэлтэй, салхины жилийн хурд  $2.2$  м/сек байдаг. Хур хэмжээ олон дунджаас үзэхэд  $258.5$  мм бөгөөд  $90\%$  нь дулааны улиралд буюу 4-9 дүгээр саруудад ордог. Өвлийн улиралд хур тунадас багатай. Тогтвортой цасан бүрхэвч 11 дүгээр сараас 3 дугаар сарын сүүлч үе хүртэл үргэлжилнэ.

**Газрын гадарга:** Хэнтийн нурууны баруун урд үзүүрт хамаарагдах Толгойт ( $1831.5$  м) уулын зүүн үзүүрт байрлана. Талбай байрлах хэсэг нь Туул голын цутгал, хөндийн системд хамаарах ба техноген үйл ажиллагааны үр дүнд газрын хэлбэр дүрс бүрэн өөрчлөгдөж хүний үйл ажиллагаатай холбоотой бохирдлын далан, инженерийн барилга байгууламжууд, тэдгээрийн хооронд холбосон зам, явган хүний замуудын нөлөөгөөр тэгш байдалтай болсон байна.

**Гадаргын болон гүний ус:** Хотын нутаг дэвсгэрийн усан сүлжээг Туул, Сэлбэ, Улиастай, Толгойт голууд тэдгээрийн салбар гол горхиуд бүрдүүлдэг. Туул голын голдирлын өргөн Улаанбаатар хотын орчимд  $44-55$  м, хуурай жилүүдэд  $5-18$  м байдаг. Гантай гачиг үед голын усны түвшин  $0.9-1.2$  м байдаг бол үерлэлтийн үедээ голын усны түвшин  $1.2-2.0$  м-ээр дээшилдэг. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр болон төслийн талбайгаас Туул гол нь  $350$  м зайд байрлаж байна. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах гүний худгаас жилд  $684$  м<sup>3</sup> ус ашигладаг байна.

**Хөрсөн бүрхэвч:** Төсөл хэрэгжих талбайн нэгж талбараас хөрсний зүсэлт хийж биологийн болон хүнд металлын бохирдлын дээж авлаа. Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Хөрсний агрохимийн шинж чанарыг харахад урвалын орчин нь хүчтэй шүлтлэг шинжийг үзүүлэх бөгөөд ялзмагийн хангамж нь хангалттай, хялбар уусах давсны агууламж  $0.193$  dS/m хэмжээтэй байна. Хөрсөн дэх хүнд металлын агууламж

нь шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсөн дэх кадми илрээгүй харин элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрсөн дэх хүлцэх агууламжаас хром, хар тугалга, зэс, никель, цайрын агууламж MNS 5850:2019 стандарт хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.

**Ургамлан нөмрөг:** Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг нь ботаник-газарзүйн мужлалаар уулын ойт хээрийн Орхон – Сэлэнгийн дэд муж, хойт хэсэг нь Хэнтийн уулын тайгын мужид хамрагдана. Хотын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэгт Өмнөд- Сибирь-Монголын умардын хэв шинжийн уулын тайгархаг ойтой. Төслийн нөлөөнд орших Толгойтын голын хөндийд алаг өвс – улалж - үетэнт (*Geranium pretence*, *Sanguisorba officinalis*, *Agropyron repens*, *Carex duriuscula*) зэрэг нугархаг ургамалшил зонхилох боловч антропогени нөлөөллийн улмаас ургамал бүрхэвч устан алга болсон байна.

### ***Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, буруулах арга зам***

"Гал импекс" ХХК нь 1971 онд "Гал" Улсын үйлдвэрийн газар нэртэй байгуулагдаж, 2002 оны 10-р сарын 22-нд хувьчлагдан, одоог хүртэл галын аюулгүй байдлын систем буюу галын дохиоллын систем угсралт, галын спринклер систем суурилуулалт, галын багаж хэрэгсэл үйлдвэрлэл, бүх төрлийн галын хорны худалдаа, цэнэглэлт, галын аюулгүй байдлын зөвлөгөө, шийдэл, сургалт, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн худалдаа, үйлдвэрлэл зэрэг үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

### ***Химийн бодисын агуулах***

Химийн бодисуудаас байгаль орчныг бохирдуулж болзошгүй эх үүсвэр:

- химийн бодисуудыг хадгалах байр, агуулах
- химийн бодисуудыг хүлээн авах, ачих буулгах талбай
- химийн бодисуудыг тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгсэл, агуулах руу зөөх, хураах тоног төхөөрөмж
- химийн бодисуудын асгаралт, хаягдал болон сав баглаа боодол

Химийн бодисын хадгалалтын болон ашиглалтын аюулгүй ажиллагааны горим алдагдсанаас уурших, галын аюул гарах, норох зэргээс хуурай, шингэн, хийн байдлаар химийн хортой бодис байгаль орчинд ялгарч, хөрс усыг бохирдуулах, амьсгал, арьс салстаар хордуулах, гадаргын болон газрын доорх усыг бохирдуулснаас ундны усаар дамжин хүний эрүүл мэндэд нөлөөлөх магадлалтай.

Үүнд:

- Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршимтгай, дэгдэмхий бодисууд агаарт ууршиж салхиар дамжин тархах; Химийн хорт бодисын хаягдлыг шатаах аргаар устгах үед хортой хий ялгарч, агаарын чанарт сөргөөр нөлөөлөх;
- Болзошгүй аюул, ослын үед ялгарах хорт хийн тархалт агаарын чанарт нөлөөлөх. Химийн бодисуудыг хадгалах агуулах, болон орчны үзүүлэлтүүдийн горим алдагдсанаас дэгдэмхий ууршимтгай бодисуудын физик төлөв, найрлагыг өөрчлөн

Уурших, исэлдэх улмаар агаарт дэгдэн гарч салхиар дамжин орчны агаарын чанар найрлагыг өөрчилнө,

- Химийн хортой бодисыг шилжүүлэн ачих, тээврийн хэрэгслийн сэлгээ хийх, эсвэл түүнийг ачсан тээврийн хэрэгслийн осол гарах үед чингэлгийн битүүмжлэл алдагдан нээгдэж улмаар хайрцаг эвдрэх болон уут сав задарвал химийн бодис асгарч, алдагдаж болзошгүй.

Мөн төслийн эдэлбэр газрын доторх шороон зам, элэгдэл, эвдрэлд орсон талбайд салхины хурд ихтэй үед тоос, тоосонцор агаарт дэгдэж орчны агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

- Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын явцад орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг хүснэгтэд нэгтгэхэд нийт нөлөөллийн 75 хувь нь “бага” үр дагавартай байгаагаас химийн бодисын агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийг “бага” зэрэг гэж үзлээ. Хөдөлгүүрт техник тоног төхөөрөмжид тогтсон хуваарийн дагуу засвар үйлчилгээг Хийх замаар яндангийн утааг багасгах
- Химийн бодис холих, уусгах үйлдлийг битүү саванд буюу хий тархахаас хамгаалсан нөхцөлд хийх
- Химийн бодисыг хадгалах агуулах, саравчийг стандартад шаардагдсан дагуу дулааны тусгаарлалтыг хийж өгөх Химийн бодисын хаягдал үлдэгдлийг үйлдвэрлэлийн хаягдал материал устгахад мэргэшсэн мэргэжлийн байгууллагаар устгуулах
- Химийн бодисын хаягдал үлдэгдлийг орон нутгийн мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл дүгнэлтийн дагуу устгах Зарим химийн бодисууд өөр хоорондоо шүргэлцсэнээр тэсэрч дэлбэрэх аюултай байдаг. Эдгээр бодисуудыг хамт ашиглах, тээвэрлэхийг хатуу хориглодог ба эдгээр бодисуудыг хүснэгтэд үзүүлэв.
- Дулааны нөлөөгөөр хортой хий ялгаруулдаг шингэн болон хатуу бодисууд гадна орчны хэт халуун температурын улмаас агаарт хий ялгаруулж, үүний улмаас агаарын чанарын найрлага алдагдан бохирддог. Агаарын чанарын үзүүлэлтүүдийг хянаж байхын тулд агаарын найрлага Монгол улсын агаарын чанарын стандартыг мөрдөнө.
- Химийн бодисуудын ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтэд орон нутгийн цаг агаарын болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд бодис хадгалах агуулах нь Химийн хорт болон аюултай бодисын агуулахыг хүн ам оршин суугаа газраас 300-аас доошгүй метрийн зайд, үер усанд автах ааргүй байрлалд байрлуулах ба агуулах нь галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн далан, хамгаалалтын сувагтай байна, Химийн бодистой холбоотой үйл ажиллагаа ашиглах, хадгалах) явуулж байгаа газруудын барилга, байгууламжийн

инженерийн төлөвлөлтийг хүчтэй салхи болон үерийн аюулд өртөхгүй байдлаар хийх шаардлагатай.

- Химийн бодистой холбоотой үйл ажиллагаа (ашиглах, хадгалах) явуулж байгаа газрууд, агуулахуудад хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх,
- Аянга зайлуулагчийг тэсэрч дэлбэрэх аюултай химийн бодистой холбоотой үйл ажиллагаа явагдаж байгаа бүх газруудад байрлуулах, Химийн бодисын нэг агуулахад 500 тонноос, агуулахын доторх нэг тасалгаанд 50 тонноос ихгүй бодис хадгалбал зохино.
- Бүх химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэр, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгална,

### Агаарын чанар

Төслийн үйл ажиллагаанд ашиглах химийн бодисуудаас агаарын чанарт нөлөөлөх хүчин зүйлс нь химийн бодис ачих буулгах, тээвэрлэх, хадгалах, ашиглах болон тэдгээрийн үлдэгдэл, хаягдлыг устгах үед гадаад орчны болон ажлын байрны агаарын чанар, найрлагыг өөрчилж болзошгүй байдлаар тодорхойлогдоно. Орчны агаарын чанарт химийн бодисууд дараах байдлуудаар нөлөөлж болно. Үүнд:

- Бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас нунтаг бодисууд агаарт дэгдэж салхиар дамжин тархах;
- Бодисын хаягдлыг шатаах аргаар устгах үед хортой хий ялгарч, агаарын чанарт сөргөөр нөлөөлөх;
- Болзошгүй аюул, ослын үед ялгарах хорт хийн тархалт агаарын чанарт нөлөөлөх.
- Бодисын хадгалалтын горим зөрчигдөх, орчны өөрчлөлт, бодис асгарах, алдагдах болон зарим болзошгүй байдлын улмаас агаарт тоосжилт, ууршилт бий болж, салхиар дамжин ойр орчмын агаарын чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөлтэй. Агаар дахь хорт хийн агууламж нэмэгдсэнээр хур тунадсаар дамжин ургамал, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Мөн төслийн эдэлбэр газрын доторх шороон зам, элэгдэл, эвдрэлд орсон талбайд салхины хурд ихтэй үед тоос, тоосонцор агаарт дэгдэж орчны агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
- Бодис хадгалах, ашиглах, барилга байгууламжид гал түймрийн аюул гарах тохиолдолд орчны агаарт хортой хий ялгарч агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй.

Дээрх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээ авна.

- Төслийн барилга байгууламжийн инженерийн төлөвлөлтийг хийхдээ газар хөдлөл, хүчтэй салхи шуурга, аянга цахилгаан, үерийн аюулыг тооцож төлөвлөх
- Гал унтраах нунтаг бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалын явцад агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх

- Галын хор цэнэглэх өрөөнд вакум сорогч, агаар сэлгэгч төхөөрөмж суурилуулах, тогтмол ажиллагааг хангах
- Химийн бодисын агуулахын барилга байгууламжийг MNS 6458-2014 стандартын дагуу байгуулах, дулааны тусгаарлалт, агааржуулалт, салхивч, гэрэлтүүлэгтэй байлгах
- Химийн бодис холих, уусгах үйлдлийг битүү саванд буюу хий тархахаас хамгаалсан нөхцөлд хийх
- Үйлдвэр, агуулахын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдэд учирсан гэмтлийг цаг тухай бүр янзалж, дотоод шаталтын хөдөлгүүрийг засварлаж, шинэчлэх
- Ногоон байгууламж байгуулах, хуурай болон салхины хурд ихтэй үед автозам, талбайг услах
- Авто тээврийн болон хүнд машин механизмын хөдөлгүүрийн сул ажиллагааг хязгаарлах, хөдөлгүүр, техник тоног төхөөрөмжид тогтсон хуваарийн дагуу засвар үйлчилгээг хийх замаар яндангийн утааг багасгах
- Үйлдвэр, агуулахын гол хэсгүүд, ажлын байр болон тогтоосон цэгт байнга тоосжилтын түвшингийн хэмжилт хийж байх ба хэрэв зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрвэл тэр даруй хяналтын арга хэмжээ авах. ОХШ-ний тэмдэглэл хөтөлж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн, анхаарах аюултай тохиолдол бүрийг судалж шаардлагатай хариу арга хэмжээг авч ажиллана.
- Агаарын чанар, дуу шуугианы хяналт шинжилгээг тогтмол хийх, ОХШ-ний тэмдэглэл хөтөлж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн, анхаарах аюултай тохиолдол бүрийг судалж шаардлагатай хариу арга хэмжээг авч ажиллана.

### Хөрсөн бүрхэвч

Орчны хөрсний чанарт химийн бодисуудын тээвэрлэлт, ашиглалт, хадгалалтаас үүсэх болзошгүй нөлөөллүүдийг доор үзүүлэв. Үүнд:

- Төслийн барилга байгуулалтын ажилд хэрэглэгдэж байгаа бодисын хадгалалт, агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн хөрсөнд их хэмжээгээр химийн бодис алдагдах,
- Тээвэрлэлт, түгээх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу явуулаагүйгээс химийн бодис хөрсөнд алдагдаж, хөрсний найрлага бүтцийг өөрчлөх,
- Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, гадаргын болон газар доорх ус, ургамал амьтанд дам нөлөөлөл үзүүлэх зэрэг болно.
- Дээрх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээ авна.
- Бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах болон устгах журамд заагдсаны дагуу алдаж асгахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй.
- Бодистой холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа агуулах, газруудын шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийх. Нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай бол арга хэмжээ авах,

- Шингэн хаягдал хаях цэгийг хөрсөнд үл нэвчүүлэх материалаар (шавар, элс) зузаан доторлож, хальж асгарахаас сэргийлэн, түвшинд байнга хэмжилт хийж байх,

Дээрх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээ авна.

- Бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах болон устгах журамд заагдсаны дагуу алдаж асгахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй.
- Бодистой холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа агуулах, газруудын шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийх. Нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай бол арга хэмжээ авах,
- Химийн бодис хадгалж байгаа болон ашиглаж буй газар үерийн хамгаалалт, даланг инженерчлэлийн нарийвчилсан үндэслэл тооцоотой хийж өгөх. Барилгын материалын цэг, шатах тослох материал, химийн бодисуудыг хадгалах цэгүүдийг ус нэвчүүлэхгүй байхаар тохижуулах, агуулах саванд тогтмол үзлэг хийж хянаж байх,
- Шингэн хаягдал хаях цэгийг хөрсөнд үл нэвчүүлэх материалаар (шавар, элс) зузаан доторлож, хальж асгарахаас сэргийлэн, түвшинд байнга хэмжилт хийж байх,
- Хөрс, болон усан орчинд бодис алдагдсан тохиолдолд тухайн бодисыг цаашид тархахаас нь сэргийлж, шингээн авах шаардлагатай. Ямар бодис алдагдсанаас шалтгаалан шингээж авах материалын нэр төрөл өөрчлөгдөх ба голдуу гадаргуугийн идэвхтэй, инерт, саармаг материал мөн элс, шороо зэрэг элбэг байх материал ашиглана.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж хэрэгжүүлнэ. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажиллах ба төслийн хог хаягдлын улмаас хөрсөн орчин бохирдохгүй байх арга хэмжээг авч ажиллана.
- Газрын төлөв байдал, чанарын баталгааг хийлгэж, газар ашиглалтын тайлан мэдээг байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу гарган тайлагнах
- Хөрсөн орчны хяналт шинжилгээг тогтмол хийх, нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай бол арга хэмжээ авах, химийн бодисын хадгалалт, ашиглалтад байнгын хяналт тавих
- Төслийн талбай орчмын ба дотоодын тээврийн замыг тэгшлэн засах, тэмдэгжүүлэх, анхааруулах самбар байрлуулах

### Гадаргын болон газрын доорх ус

"Галын аюулгүй байдлын багаж, хэрэгслийн агуулах, үйлдвэр" төслийн үйл ажиллагаанд шаардагдах ахуйн болон технологийн усыг Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн системээс хангадаг.

- Химийн бодисын агуулахын төлөвлөлт, байршлын сонголт, барилга байгууламжийн хийцийн доголдлоос үүдэн гадаргын ус болон хур борооны түр урсцад химийн бодис алдагдах, мөн усны урсцаар дамжин тархаж, голдирлын дагуух усны нөөцийг бохирдуулах
- Химийн бодисоор бохирдсон усыг хөрс, усны урсцын голдиролд алдсанаас гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах
- Барилга байгууламжийн үерийн хамгаалалт муу байх, инженерийн төлөвлөлтийн алдаа зэргээс үүдэн химийн бодис хадгалагдаж байгаа зарим агуулах түр зуурын үерийн аюулд өртөж болзошгүй. Мөн ашиглалтаас илүү гарсан болон хаягдал бодис, материал хуримтлагдсан үед аливаа осол аваар гарах, байгалийн аюултай үзэгдэл тохиолдох нөхцөлд байгаль орчинд алдагдаж болзошгүй.

### Ургамлан нөмрөг

- Төслийн талбай нь хүний нөлөөгөөр талхлагдаж хүмүүнсэг ургамал тархсан боловч нөлөөллийн үнэлгээний матрицаас үзвэл төсөл хэрэгжүүлэх явцад агаар болон хөрсөн орчинд алдагдах бодис нэгдлүүд нь ургамлан бүрхэвчид дам байдлаар нөлөөлнө гэж үзлээ.
- Төслийн талбай нь удаан хугацаанд хүний үйл ажиллагаанд тогтвортой ашиглагдсан төдийгүй барилга байгууламж нэгэнт баригдсан тул байгалийн ургамалжилттай талбай одоогоор байхгүй ч тодорхой хэмжээнд ногоон байгууламж бий болгох нь зүйтэй.

### Амьтны аймаг

- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Улаанбаатар хотын үйлдвэрийн бүсэд хамаарч байгаагаас гадна уг төслийн талбайд барилга байгууламж нэгэнт баригдсан тул хөхтөн, хоёр нутагтан, мөлхөгч зэрэг ангийн амьтад байхгүй, харин шувуудаас хүнд ойромсог (синантроп) зүйлүүд барилга байгууламжид үүрлэж болзошгүй. Хог хаягдал, ариун цэвэр бохирын асуудлыг сайтар төлөвлөхгүй бол хүнд ойр амьдардаг, хог хаягдлын индикатор гэгдэх зүйлүүдийн тоо өсөх магадлалтай.

### Хог хаягдал

Төслийн хүчин чадал, түүхий эдийн талаарх төсөл хэрэгжүүлэгчийн өгсөн мэдээлэл болон Засгийн газрын 2015 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан хог хаягдлын норматив тогтоох аргачлалаар төслийн технологийн хаягдлын хэмжээг тооцоход нийт технологийн хатуу хаягдлын 90 гаруй хувь нь цаасан хайрцаг, сав баглаа боодол эзэлж байна. Харин галын

хорны бортого болон NO<sub>2</sub>, CO<sub>2</sub> бүхий өндөр даралтат хийн хаягдал буюу дууссан баллон 0,5 хувийг эзэлж байна. Хөнгөн цагаан хийн бортогог шууд хаяхгүй, дахин ашиглах бүрэн боломжтой тул үйлдвэрлэлээс гарах химийн бодисын шуудай, сав 1 орчим хувийг эзэлж байна.

- Шингэн хаягдлын хувьд галын хор цэнэглэх үйл явцад ус ашиглахгүй ч ажилчдын ахуйн хэрэглээ, цех, хэсгүүдийн өрөө тасалгаа, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээнээс гарах шингэн хаягдлыг үүнд хамааруулж байна.
- Ахуйн хатуу хог хаягдал нь ажилчдын хоолны үлдэгдэл, ахуйн хэрэглээнээс гарсан хаягдал байна. Нэг хүн өдөрт 0.3кг хатуу хог хаягдал гаргана гэж үзвэл, төслийн явцад өдөрт 18 кг, сард 378 кг хатуу хог хаягдал гарахаар байна.

### **Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний зөвлөмж**

Төслийн үйл ажиллагааг хэвийн явуулах, химийн бодистой холбоотой эрсдэл үүсгэхгүй байх нөхцөлийг хангах зорилгоор дараах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг зөвлөж байна.

- Химийн бодисыг “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах” стандартын шаардлага хангасан зориулалтын агуулахад хадгална.
- Химийн бодис нь зориулалтын сав, баглаа боодол, стандартын шаардлага хангасан хаяг, шошготой байх.
- Агуулахад хадгалж буй химийн бодисын хор, аюулын шинж чанараас нь хамааруулан зохих анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор байрлуулах,
- Аюулгүй ажиллагааны зааварчилгааг үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн химийн бодис, бүтээгдэхүүн нэг бүрээр боловсруулсан байх. Ижил шинж чанартай хэд хэдэн бодист нэг аюулгүй ажиллагааны зааварчилгаа байж болно
- Аюулгүй ажиллагааны зааварчилгаа нь доорх мэдээллийг үгэн болон дүрс хэлбэрээр ойлгомжтой илэрхийлсэн байна.
  - ✓ химийн бодисын хор аюул, үүсэж болох эрсдэл: хүний эрүүл мэнд болон байгаль орчинд;
  - ✓ химийн бодистой харьцах/хадгалах зааварчилгаа;
  - ✓ асгарч алдагдсан үед авах арга хэмжээ;
  - ✓ галын аюул гарсан үед авах арга хэмжээ;
  - ✓ анхны тусламж үзүүлэх зааварчилгаа;
  - ✓ ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл, хэрэглэх заавар;

### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### 3.1 Төслөөс агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Химийн бодисын агуулахад хадгалагдах бодисуудыг хадгалахдаа аюулгүйн ажиллагааны дүрмийг баримтлаагүй улмаас химийн бодис ихээр алдагдсанаар агаарт дэгдэж хүний эрүүл мэндэд нөлөөлж болох ба бодис алдагдсан цаг тухайд саармагжуулах аргыг хэрэглэвээс нөлөөллийн үргэлжлэх хугацаа нь харьцангуй бага байна. Мөн хог хаягдлыг ил задгай зөвшөөрөгдсөн ангиллын дагуу бус устгаснаас нөлөөлөл үүсэж болзошгүй юм. Агаарын бохирдол нь хамрах хүрээ хязгаарлагдмал, бодис бүрийг зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу устгавал агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл бага болно.

#### Хүснэгт 2. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Үйл ажиллагаа	Боломжит болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн тохиолдох магадлал давтамж	Зэрэглэл	Нөлөөллийн үнэлгээ	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
1	Химийн бодис тээвэрлэлт	Газраар тээвэрлэлтэд тоос шороо босох	1-Хөнгөн	D-Бага	D-1	Бага	Тээвэрлэлтийн аль болох төмөр замаар тээвэрлэх
2	Химийн бодис ачиж буулгах	Химийн бодисын сав баглаа боодлын гэмтлээс асгаралт гоожилтоос агаарт дэгдэх	2-Дунд зэрэг	B-Өндөр	B-1	Дунд	Химийн бодисын бүртгэлийг ачиж буулгах бүх үйл явцад хийж байх
3	Химийн бодис хадгалалт	Хадгалалтын горим алдагдаж агаарт их хэмжээний хортой хий ялгарах	2-Дунд зэрэг	B-Өндөр	B-1	Дунд	Химийн бодис хадгалах агуулахын агааржуулалт, галын аюулын байдлыг сайтар мөрдөж ажиллах
4	Химийн бодис асгаралт	Агаарт орчинд тархан, хөрсөн бүрхэвч, газрын доорх ус бохирдох	2-Дунд зэрэг	B-Өндөр	B-2	Их	Химийн бодис тээвэрлэлт болон ашиглалтын үед хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах

Галын аюулгүй байдлын багаж хэрэгслийн агуулах, үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхэд агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг нийт 4 үйл ажиллагаанаас 4 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 25% нь бага, 50% нь дунд, 25% нь их нөлөөллийн зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд химийн бодисын агуулах төслийн агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь

нөлөөллийн хувьд дунд түвшинд байгаа учир агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах менежментийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Төслийн үйл ажиллагаанд ашиглах химийн бодисуудаас агаарын чанарт нөлөөлөх хүчин зүйлүүд нь химийн бодисуудыг ачих буулгах, тээвэрлэх, хадгалах болон тэдгээрийн үлдэгдэл, хаягдлыг устгах үед гадаад орчны болон ажлын байрны агаарын чанар, найрлагыг өөрчилж болзошгүй байдлаар тодорхойлогдоно. Орчны агаарын чанарт химийн бодисууд дараах байдлаар нөлөөлж болно. Үүнд:

Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршимтгай, дэгдэмхий бодисууд агаарт ууршиж салхиар дамжин тархах;

-Химийн хорт бодисын хаягдлыг шатаах аргаар устгах үед хортой хий ялгарч, агаарын чанарт сөргөөр нөлөөлөх;

-Болзошгүй аюул, ослын үед ялгарах хорт хийн тархалт агаарын чанарт нөлөөлөх.

-Химийн бодисуудыг хадгалах агуулах, болон орчны үзүүлэлтүүдийн горим алдагдсанаас дэгдэмхий ууршимтгай бодисуудын физик төлөв, найрлагыг өөрчлөн уурших, исэлдэх улмаар агаарт дэгдэн гарч салхиар дамжин орчны агаарын чанар найрлыг өөрчилнө.

-Химийн хортой бодисыг шилжүүлэн ачих, тээврийн хэрэгслийн сэлгээ хийх, эсвэл түүнийг ачсан тээврийн хэрэгслийн осол гарах үед чингэлгийн битүүмжлэл алдагдан нээгдэж улмаар хайрцаг эвдрэх болон уут сав задарвал химийн бодис асгарч, алдагдаж болзошгүй.

-Бодисуудын шатамхай чанарыг тодорхойлоход түүний ноцох температур чухал үзүүлэлт бөгөөд энэ температурт тухайн бодис ямар нэгэн галын эх үүсвэртэй хүрэлцсэнээр хялбар гал авалцаж, шаталт явагддаг. Шингэн бодисууд дулааны нөлөөгөөр эзлэхүүн нь тэлж, улмаар савнаасаа хальж асгардаг. Ингэснээр газрын хөрсөнд нэвчин орж хөрс, ургамал, болон газрын доорх усыг бохирдуулдаг.

-Хадгалалтын горим зөрчигдөх гадаад орчны хэт халалт, агаарын чийгшил ихсэх, асгарах, алдагдах болон зарим болзошгүй эрсдэлийн нөлөөгөөр бордооны чанар муудах магадлалтай.

### **3.2. Төслөөс усны чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

Төсөл хэрэгжих газрын ойр орчимд уст цэг байхгүй. БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчны, байгалийн нөөцийн удирдлагын газрын Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн лавлагаагаар Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны “Нийслэл хотын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” 69 дугаар тогтоолоор батлагдсан усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүстэй тус тус давхцалгүй байна. БОАЖСайд, БХБСайдын хамтарсан 2018 оны А/02/01 дугаар тушаалаар баталсан “Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт болон хязгаарлалтын бүстэй давхцалгүй, тэжээгдлийн муж”-тай бүтэн давхцалтай байна. Хавсралтаар лавлагааг харуулав. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А-230/127 тоот Журам батлах тухай тушаалын 3.11 -г зөрчиж байна. Гэхдээ тухайн төсөл нь ус ашиглахгүй. Ахуйн хэрэглээний усаа төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. УСУГ-тай гэрээ байгуулсан байна. Харин химийн бодис асгарсан тохиолдолд

хөрсөөр дамжин гүний усыг бохирдуулах нөлөөтэй. Хэрвээ газрын доорх усанд алдагдах нөхцөлд удаан хугацаанд хадгалагдах магадлалтай юм.

Орчны усны найрлага, чанарт химийн бодисуудын тээвэрлэлт, ашиглалт, хадгалалтаас үүсэх болзошгүй нөлөөллүүдийг доор үзүүлэв. Үүнд:

Тээвэрлэлт, хадгалах, үйлдвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодис асгарах, талбайд татан ирэх явцад түр зуурын үерт өртөж, тухайн урсцын усыг бохирдуулах, бохирдлын эх үүсвэр бий болгох,

Химийн бодис ашиглаж байгаа газруудад хэрэглээний нормоос илүү болон ашиглалтгүй химийн бодисын хуримтлал үүссэнээс хур бороо орж гадаргын ус үүссэн үед уг усыг бохирдуулах. Мөн тухайн цэгт химийн бодисоор бохирдсон усыг технологийн горим зөрчиж хөрс, түр зуурын урсцын голдиролд алдсанаас гадаргын болон газар доорх ус бохирдох зэрэг болно.

Хортой, аюултай бодисын хадгалалт, устгалын шаардлага хангаагүйгээс хортой, аюултай химийн бодис, эсвэл хоорондоо үл нийцэх бодисууд нэгдэж болзошгүй аюул бий болох, ашигласан бодисуудын хаягдлыг устгалын шаардлага хангахгүйгээр шууд хаяснаар усан орчинд шууд болон дам нөлөө үзүүлэх магадлалтай юм. Иймд галын аюулгүй байдлын багаж хэрэгслийн агуулах, үйлдвэрийн төслийн хувьд аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах шаардлагатай. Мөн хадгалалтын явцад химийн бодисыг ил задгай байлгахгүй, зориулалтын агуулахад үл нэвтчүүлэх цементэн шалтай талбайд зориулалтын газрын гадаргаас 50 см дээр тавцан дээр хадгалах шаардлагатай.

### Хүснэгт 3. Усны нөөц, чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Үйл ажиллагаа	Боломжит болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн тохиолдох магадлал давтамж	Зэрэглэл	Нөлөөллийн үнэлгээ	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
1	Химийн бодис ачиж буулгах	Химийн бодисын сав баглаа боодлын гэмтлээс асгаралт гоожилтоос хөрсөн бүрхэвчид нэвчиж улмаар газрын доорх ус бохирдох	1-Хөнгөн	D-Бага	D-1	Бага	Химийн бодисын агуулахын бодис ачиж буулгах талбайн бүрэн цементжүүлэх
2	Химийн бодис хадгалалт	Тус агуулахад ихэнхдээ шатах эрсдэлтэй бодисууд хадгалагдаж байгаа тул хадгалахын	1-Хөнгөн	D-Бага	D-1	Бага	Химийн бодис хадгалах агуулахын агааржуулалт, галын аюулын байдлыг сайтар мөрдөж ажиллах

		горимыг баримтлах					
3	Химийн бодис асгаралт	Хөрсөөр дамжин гүний усанд нөлөөлөх	1-Хөнгөн	D-Бага	D-1	Бага	Химийн бодис тээвэрлэлт болон ашиглалтын үед хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах

Химийн бодисын агуулах төслийг хэрэгжүүлэхэд усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөллийг нийт 3 үйл ажиллагаанаас 3 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 100% нь бага нөлөөллийн зэрэгт хамрагдаж байна.

### 3.3. Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

“Гал импекс” ХХК-ийн Галын аюулгүй байдлын багаж хэрэгслийн агуулах, үйлдвэрийн төсөл нь хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл бага юм. Химийн бодисуудаас хөрсний чанарт цөөн хэдэн хүчин зүйлсээр нөлөөлөхөөр байна. Орчны хөрсний чанарт химийн бодисуудын тээвэрлэлт, ашиглалт, хадгалалтаас үүсэх болзошгүй нөлөөллүүдийг доор үзүүлэв. Үүнд:

- Тээвэрлэлт, түгээх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх,
- Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, гадаргын болон газар доорх ус, ургамал амьтанд дам нөлөөлөл үзүүлэх зэрэг болно,
- Тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэх нь тухайн бүсийн хөрсний бохирдол өсөх, бохирдуулагч бодисын хуримтлал үүсэх нөхцөлийг бий болгох бөгөөд ингэснээр, хөрсөн дэх техноген бохирдуулагч бодисын хэмжээ нэмэгдэх
- Автомашины утаанаас гарах хар тугалга зэрэг хорт бодис нь зам орчмын хөрсөнд, хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлөх
